



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/30/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ 2021
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: tsaranchimeg@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.1 Төлбөрийн акт.....	16
4.2 Албан шаардлага.....	16
4.4 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТЕЗ Төсвийн ерөнхийлөн захирагч



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/132
танай -ны № -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ
19020422

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,059,887.99	3,705,649.99
35	БАРАА МАТЕРИАЛ	3,059,887.99	3,705,649.99
354	Хангамжийн материал	3,059,887.99	3,705,649.99
35410	Бичиг хэргийн материал	822,840.00	832,840.00
35420	Аж ахуйн материал	1,043,520.00	2,336,270.00
35430	Сэлбэг хэрэгсэл	260,000.00	260,000.00
35440	Түлш, шатах тослох материал	933,527.99	276,539.99
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	35,269,786.83	25,915,863.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	35,269,786.83	25,915,863.35
392	Биет хөрөнгө	34,790,453.69	25,915,863.35
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,000,000.00	33,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-9,624,999.93	-15,124,999.89
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	15,206,937.00	12,869,450.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-8,369,848.76	-8,499,855.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,305,405.00	8,305,405.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,727,039.62	-4,634,136.50
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-850,666.86	-880,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	38,329,674.82	29,621,513.34
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	103,229.79	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	103,229.79	00.00
413	Өглөг	103,229.79	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	103,229.79	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	38,226,445.03	29,621,513.34
51	Засгийн газрын хувь оролцоо	38,226,445.03	29,621,513.34
512	Хуримтлагдсан үр дүн	38,226,445.03	29,621,513.34
51210	Өмнөх үеийн үр дүн	38,226,445.03	38,226,445.03
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-8,604,931.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	38,329,674.82	29,621,513.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	159,311,000.00	163,678,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	159,311,000.00	163,678,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	159,311,000.00	163,678,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн	159,311,000.00	163,678,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	165,248,589.88	171,833,231.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	165,248,589.88	171,833,231.69
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	163,258,589.88	168,622,231.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	101,550,992.19	119,082,186.15
210101	Үндсэн цалин	101,550,992.19	119,082,186.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,774,065.13	15,209,604.19
210201	Тэтгэврийн даатгал	8,702,284.51	10,457,025.68
210202	Тэтгэмжийн даатгал	1,025,070.86	1,188,144.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	812,455.51	950,515.70
210204	Ажилгүйдлийн даатгал	203,114.39	237,628.68
210205	Эрүүл мэндийн даатгал	2,031,139.86	2,376,289.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,124,178.40	5,124,178.40
210302	Түлш, халаалт	5,124,178.40	5,124,178.40
2104	Хангамж, бараа материалын зардал	5,515,675.80	6,567,137.00
210401	Бичиг хэрэг	778,448.00	1,370,850.00
210402	Тээвэр, шатахуун	2,808,332.00	3,425,988.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,202,128.30	976,829.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	726,767.50	793,470.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	311,900.00
210604	Урсгал засвар	00.00	311,900.00
2107	Томилолт, зочны зардал	4,388,500.00	9,579,000.00
210702	Дотоод албан томилолт	4,388,500.00	9,579,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	526,600.00	492,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	143,100.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	62,500.00	52,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,378,578.36	12,255,475.95
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,828,500.00	530,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,747,488.08	8,903,923.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,990,000.00	3,211,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,990,000.00	3,211,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,990,000.00	3,211,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-5,937,589.88	-8,154,931.69
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	450,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	450,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-450,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-5,937,589.88	-8,604,931.69

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	6,700,738.09	00.00	6,700,738.09
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	6,700,738.09	00.00	6,700,738.09
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	3,628,003.05	00.00	3,628,003.05
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	38,226,445.03	00.00	38,226,445.03
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	38,226,445.03	00.00	38,226,445.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	38,226,445.03	00.00	38,226,445.03
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,604,931.69	00.00	-8,604,931.69
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	29,621,513.34	00.00	29,621,513.34

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	159,311,000.00	163,678,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	159,311,000.00	163,678,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	159,311,000.00	163,678,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	159,311,000.00	163,678,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	157,311,200.00	163,678,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	157,311,200.00	163,678,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	132,586,109.72	157,590,247.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	101,515,088.45	118,899,138.87
210101	Үндсэн цалин	71,978,010.55	79,670,624.06
210102	Нэмэгдэл	27,299,077.90	35,692,514.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,238,000.00	3,536,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,774,239.07	15,440,381.26
210201	Тэтгэврийн даатгал	8,632,215.35	10,660,159.12
210202	Тэтгэмжийн даатгал	1,095,354.71	1,194,855.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	812,444.48	955,724.46
210204	Ажилгүйдлийн даатгал	203,111.38	239,131.08
210205	Эрүүл мэндийн даатгал	2,031,113.15	2,390,511.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,124,178.40	5,124,178.40
210302	Түлш, халаалт	5,124,178.40	5,124,178.40
2104	Хангамж, бараа материалын зардал	6,429,003.80	5,785,179.00
210401	Бичиг хэрэг	950,608.00	1,347,020.00
210402	Тээвэр, шатахуун	3,317,000.00	2,784,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,266,128.30	971,659.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	895,267.50	682,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	1,676,600.00
210604	Урсгал засвар	00.00	1,676,600.00
2107	Томилолт, зочны зардал	3,567,000.00	9,579,000.00
210702	Дотоод албан томилолт	3,567,000.00	9,579,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	526,600.00	438,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	280,000.00	233,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	130,000.00	108,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	86,600.00	71,450.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	25,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,650,000.00	647,720.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,650,000.00	647,720.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,725,090.28	6,088,052.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,922,500.00	3,266,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,922,500.00	3,266,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,802,590.28	2,821,552.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,802,590.28	2,821,552.47

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	159,311,000.00	136,508,409.72	163,678,300.00	160,856,747.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	159,311,000.00	136,508,409.72	163,678,300.00	160,856,747.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	157,311,000.00	134,585,909.72	160,411,600.00	157,590,247.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	110,050,700.00	101,515,088.45	119,206,800.00	118,899,138.87
210101	Үндсэн цалин	73,990,800.00	71,978,010.55	78,198,300.00	79,670,624.06
210102	Нэмэгдэл	33,350,900.00	27,299,077.90	37,384,500.00	35,692,514.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,709,000.00	2,238,000.00	3,624,000.00	3,536,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлбөр	14,856,000.00	12,774,239.07	16,092,900.00	15,440,381.26
210201	Тэтгэврийн даатгал	10,454,400.00	8,632,215.35	11,324,600.00	10,660,159.12
210202	Тэтгэмжийн даатгал	1,100,400.00	1,095,354.71	1,192,100.00	1,194,855.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	880,800.00	812,444.48	953,700.00	955,724.46
210204	Ажилгүйдлийн даатгал	219,600.00	203,111.38	238,400.00	239,131.08
210205	Эрүүл мэндийн даатгал	2,200,800.00	2,031,113.15	2,384,100.00	2,390,511.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,228,800.00	5,124,178.40	5,247,800.00	5,124,178.40
210302	Түлш, халаалт	9,028,800.00	5,124,178.40	5,127,800.00	5,124,178.40
2104	Хангамж, бараа материалын зардал	7,578,300.00	6,429,003.80	6,015,600.00	5,785,179.00
210401	Бичиг хэрэг	1,479,000.00	950,608.00	1,462,000.00	1,347,020.00
210402	Тээвэр, шатахуун	3,776,000.00	3,317,000.00	2,784,000.00	2,784,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,373,300.00	1,266,128.30	977,700.00	971,659.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд	950,000.00	895,267.50	791,900.00	682,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	594,900.00	00.00	1,684,100.00	1,676,600.00
210604	Урсгал засвар	594,900.00	00.00	1,684,100.00	1,676,600.00
2107	Томилолт, зочны зардал	8,752,300.00	3,567,000.00	11,056,100.00	9,579,000.00
210702	Дотоод албан томилолт	8,752,300.00	3,567,000.00	11,056,100.00	9,579,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	550,000.00	526,600.00	458,300.00	438,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоо	280,000.00	280,000.00	233,300.00	233,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	130,000.00	130,000.00	108,300.00	108,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	110,000.00	86,600.00	91,700.00	71,450.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00	25,000.00	25,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	470,000.00	464,980.00	650,000.00	647,720.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,700,000.00	4,649,800.00	650,000.00	647,720.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	1,922,500.00	3,266,700.00	3,266,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	1,922,500.00	3,266,700.00	3,266,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалт	2,000,000.00	1,922,500.00	3,266,700.00	3,266,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	159,311,000.00	159,311,000.00	163,678,300.00	163,678,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	159,311,000.00	159,311,000.00	163,678,300.00	163,678,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	159,311,000.00	159,311,000.00	163,678,300.00	163,678,300.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	7	0	7	7
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	6	6	6	6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Байхгүй.

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой анхан шатны баримтын бүрдүүлэлт болох е баримт, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн № 33/09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт хийх үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиг үүрэгтэй байгууллага юм.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын 2015 оны 12 дугаар сарын А/07 тушаалаар дотоод хяналтын журмыг батлан, мөрдөн ажилласан байна. 2021 оны байгууллагын дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нягтлан бодох бүртгэл анхан шатны бүртгэл хөтлөлт албан хаагчдын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтад дотоод хяналт шалгалт хийсэн байна.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны үйл ажиллагаанд Сангийн яамны Санхүү хяналт, эрсдэлийн удирдлагын газраас чанарын хяналт хийгдсэн боловч шалгалтын үр дүнгийн талаар материал ирүүлээгүй байна.

Төв аймаг дахь Төрийн аудитын газраас “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт” сэдэвтэй гүйцэтгэлийн аудит хийгдсэн байна.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 159,311.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 2,389.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 1,792.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 2,455.2 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 65.5 мянган төгрөгөөр өссөн байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 1,841.4 мянган төгрөгөөр тогтоосон байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Аймгийн ТЕЗ-ийн байгууллагуудад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд орон нутгийн төсвөөс 163,678.3 мянган төгрөг, нийт 168,045.6 мянган төгрөг өмнөх оноос 4,367.3 мянган төгрөгөөр буюу 2,7 хувиар өссөн байна.

Зардал:

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 171,833.2 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 163,678.3 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 160,856.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100140051004 тоот дансанд 2021 онд 163,696.3 мянган төгрөгийн орлого, 163,696.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	3,059.9	3,705.6	645.7
Нөөцийн бараа /сурах бичиг/	-	-	-
Үндсэн хөрөнгө	35,269.8	25,915.9	(9,353.9)
Нийт хөрөнгө	38,329.7	29,621.5	(8,708.2)
Өр төлбөр	103.2	-	(103.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	38,226.5	29,621.5	(8,605.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	38,329.7	29,621.5	(8,708.2)

Бараа материалын дансны үлдэгдэл 3,705.6 мянган төгрөг болж 645.7 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материалын дансанд паркет, ам дарагч нийт 1,322.7 мянган төгрөгөөр материал бэлтгэснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 25,915.9 мянган төгрөг болж 9,353.9 мянган төгрөгөөр буурсан нь Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 27 тоот тогтоолоор 2,337.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 450.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө акталж, шийдвэрийн дагуу данснаас хассанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 29,621.5 мянган төгрөг болж 8,605.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 220,353.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 220,353.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 56,675.3 мянган төгрөгөөр бууруулж орон нутгийн төсвөөс 163,678.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь цалин, шимтгэл 32,358.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 7,172.4 мянган төгрөг, тогтмол зардал 4,312.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 3,200.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 2,409.9 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 163,378.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 163,678.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 163,378.3 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 160,856.7 мянган төгрөгийг зарцуулж, 2,821.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 160,856.7 мянган төгрөг буюу 98,3 хувь зарцуулсан нь томилолтын зардал 1,477.1 мянган төгрөг, цалин, шимтгэлийн зардал 960.1 мянган төгрөг хэмнэснээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Тус байгууллага тайлант онд нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд онцолсон асуудал байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 160,856.7 мянган төгрөгийн төсвийн зарцуулалтаас 83,5% буюу 134,339.5 мянган төгрөг нь цалин, шимтгэлийн зардал эзэлж байна. Бусад зардал нийт зардлын 16,5% буюу 26,517.2 мянган төгрөгийг эзэлж байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 2 байна. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг бүрэн байршуулсан эсэхийг шалгасан. Мэдээллийг бүрэн оруулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны мэдээллийг бүрэн оруулах, төлбөрийн шилжүүлгийг е баримтаар баталгаажуулж ажиллах 2 зөвлөмжийг 80.0% хэрэгжүүлэн ажиллаж Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын 2021 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн 33/47 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,267.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 291.9 мянган төгрөгийн алдааг залруулж, материаллаг 1,300.0 мянган төгрөгийн болон материаллаг бус 646.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Буцалтгүй тэтгэмжийн 200.0 мянган төгрөгийг өглөгийн дансаар дамжуулалгүй шууд зардалд хаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Цалингийн өглөгийн дансаар дамжуулах цалингийн зардлын бичилтийн 91.9 мянган төгрөгийн гүйлгээг НДШ, Татварын өглөгийн дансаар хааж буруу бичилт хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.1 Төлбөрийн акт

Аудитын явцад төлбөрийн акт бичигдээгүй болно.

4.2 Албан шаардлага

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр 1,330.0 мянган төгрөгийг Коун ханэ ХХК рүү бараа материалын үнийг шилжүүлж урсгал засварын материал нөөцөлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 тоот тогтоолоор батлагдсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.1-д үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” үүссэн бол албан шаардлага тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулганы дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн 646.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх зааврын 6.5-

д заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” үүссэн бол албан шаардлага тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба	4	2,267.9	2	291.9	0	0	2	1,976.0	0	0